



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2020 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А - 192

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, 10.3 дахь хэсгийг тус тус үндэслэн, банкны санхүүгийн байдлыг сайжруулж, банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах зорилгоор ТУШААХ нь:

1.“Монголбанкнаас банканд олгох зээлийн түр журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.“Монголбанкнаас банканд олгох зээлийн түр журам”-ыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал мөрдсүгэй.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан), Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул)-д тус тус даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН